



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 29 өдөр

Дугаар А/332

Алтай хот

Малын түүвэр судалгаа явуулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-ийн "в" дэх заалт, 18 дугаар зүйл, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2 дахь хэсэг, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйл, Зөрчлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.21.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2023 оны хагас жилийн малын түүвэр судалгааг удирдан зохион байгуулж, хяналт тавих аймгийн ажлын хэсгийг нэгдүгээр, сумдын комиссыг хоёрдугаар, сумдын тооллогын комиссын дарга бөгөөд Засаг дарга нарын чиг үүргийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Малын түүвэр судалгааны бэлтгэлийг сайтар хангаж, холбогдох хууль тогтоомж, Үндэсний статистикийн хорооноос ирүүлсэн заавар, зөвлөмжийг баримтлан тогтоосон хугацаанд чанартай зохион байгуулахыг ажлын хэсэг (Г.Чинбат)-т даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 20... оны ...
дугаар сарын-ны өдрийн дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга: Г.Чинбат (Аймгийн Засаг даргын орлогч)
Орлогч дарга: Д.Тунгалаг (Статистикийн хэлтсийн дарга)
Гишүүд: Х.Баатарзориг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)
Т.Сүхбаатар (Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Д.Наянбуу (Мал эмнэлгийн газрын дарга)
С.Баярмаа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө
оруулалтын хэлтсийн хүнс, хөдөө аж
ахуйн бодлого хариуцсан мэргэжилтэн)
Нарийн бичгийн дарга: Ч.Чулуунцэцэг (Статистикийн хэлтсийн мэргэжилтэн)

__оОо__

Аймгийн Засаг даргын 20... оны ...
дугаар сарын ...-ны өдрийн ... дугаар
захирамжийн гуравдугаар хавсралт

**СУМДЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА,
ЗАСАГ ДАРГА НАРЫН ЧИГ ҮҮРЭГ**

1.Малын түүвэр судалгааны үеэр гарсан асуудлыг орон нутгийн түвшинд шуурхай шийдвэрлэж, зохих арга хэмжээг авч ажиллахаас гадна өгсөн үүргийн чиглэл, зааврыг баримтлаагүй, хариуцлагагүй, хойрго хандсан байгууллага, ажилтан, иргэдэд тухай бүр хариуцлага тооцох.

2.Малын түүвэр судалгааг 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрөөс 06 дугаар сарын 06-ны өдрүүдэд нэгэн зэрэг зохион байгуулж, үр дүнг нэгтгэн 06 дугаар сарын 19-ний дотор дуусгаж, Статистикийн хэлтэст хүлээлгэн өгөх.

3.Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу улсын хэмжээнд явагдаж байгаа малын хагас жилийн түүвэр судалгааны ажилтай давхардуулан аливаа олныг хамруулсан ажлыг зохион байгуулахгүй байх, тооллогод оролцож буй ажилтнуудыг оролцуулахгүй байхад онцгойлон анхаарах.

4.Малын түүвэр судалгааны үр дүнгээр малын индексжүүлсэн даатгалд даатгуулсан малчдад хоролдсон малын нөхөн төлбөрийг олгодог учир сонгогдсон өрхийг бүрэн хамруулж, маягт зааврын дагуу бүрэн хөтөлж мэдээллийн чанарт онцгойлон анхаарах.

5.Малын түүвэр судалгааны олгогдсон санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулж, дутагдсан санхүүжилтийг орон нутагтаа зохицуулалт хийж ажиллах.

__оОо__

Аймгийн Засаг даргын 20... оны ...
дугаар сарын ...-ны өдрийн ... дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

СУМДЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН
БҮРЭЛДЭХҮҮН

Тооллогын комиссын дарга: -Засаг даргын орлогч

Гишүүд:

- Засаг даргын Тамгын газрын дарга
- Санхүүгийн албаны дарга
- Мал үржлийн тасгийн албан хаагчид
- Мал эмнэлгийн тасгийн албан хаагчид
- Цагдаагийн хэсгийн төлөөлөгч
- Багийн Засаг дарга нар
- Даатгалын төлөөллүүд

Нарийн бичгийн дарга:

- Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн

__оОо__